



LEGAL NEWSLETTER

2024 April №44

AKP Law Firm

Бид энэ оны 4 дүгээр сард батлагдсан онцлох хууль тогтоомжоос танилцуулж байна.

1.1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

- 2024 оны 04 дүгээр сар 12-ны өдөр батлагдсан энэ хууль нь Төрийн мэдээлэл гарсан өдрөөс буюу 5 сарын 1-ны өдрөөс хэрэгжиж эхэллээ.
- Энэ хуулиар Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дараах заалтыг хүчингүй болгов.

12.1.1 "газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах"

- Мөн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн "Газрын тухай," гэснийг хассан.

12.2.Татварын бус хөрөнгө оруулалты н дэмжлэгийг Чөлөөт бүсийн тухай, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.2. ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ

- 2024 оны 4 дүгээр сарын 19-ны өдөр батлагдсан энэ хуулийг 5 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- Энэ хуулиар мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаан буудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөллөө.

- 2024 оны 4 дүгээр сарын 19-ны өдөр батлагдсан энэ хуулийн зарим заалтыг 2024 оны 4 сарын 24-ний өдрөөс, зарим заалтыг 12 сарын 31-ний өдрөөс мөрдөнө.
- Энэ хуулийн зорилт нь уламжлалт мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, малчдад учирсан эрсдэлийг бууруулах арга хэмжээг онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэ хууль батлагдсанаар хөдөө орон нутагт малчдын хоршоо байгуулах, тэдгээрт барьцаа хөрөнгө, батлан даалтгүйгээр зээл олгох, мөн мал аж ахуйн зориулалтаар 5 га газрыг эзэмших эрх олгох, үйл ажиллагааг төрийн байгууллагаас дэмжих эрх зүйн орчин бүрдсэн.

1.4. ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ

- 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан энэ хууль нь 5 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
- Энэ хуулийн зорилт нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор Үндэсний баялгийн санг байгуулах, түүний төрөл, зориулалт, эх үүсвэрийг тодорхойлох, сангийн хөрөнгийн тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- Эдгээр сангийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, Сангийн яаманд ирүүлнэ.
- Үндэсний баялгийн сан нь дотроо дараах 3 сангаас бүрдэнэ.

Төрөл	Зориулалт
Ирээдүйн өв сан	газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор хуримтлуулах, хуримтлагдсан хөрөнгийг олон улсын зах зээлийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар

	өнөөгийн үнэ цэнийг өсгөх, арвижуулах;
Хуримтлалын сан	газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх;
Хөгжлийн сан	газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан эдийн засаг, нийгмийн үр өгөөж бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь; Мөн сангийн хөрөнгө оруулалтын орлого.
Хуримтлалын сан	уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцааны ногдол ашиг
Хөгжлийн сан	нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан тохиолдолд гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байснаас нэмэгдэж орох төсвийн орлогын 50 хувиас бүрдэнэ.

Дээрх агуулгатай холбоотой бусад дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар илгээнэ үү.

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Pearl tower А блок 1201 тоот
 Web: www.akp.mn
 E-mail: contact@akp.mn
 Tel: 7704-1414, 9511-3680

- Сангийн эх үүсвэр дараах болно.

Төрөл	Эх үүсвэр
Ирээдүйн өв сан	ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр буюу АМНАТ-аас Төсвийн тогтворжуулалтын болон